

УУЛ УУРХАЙ БА ХҮНИЙ ХӨГЖИЛ

БАЙГАЛИЙН БАЯЛГИЙН ӨГӨӨЖИЙГ ИНСТИТУЦИ
БОЛОН ХҮНИЙ ХӨГЖИЛД ЧИГЛҮҮЛЭХ НЬ



ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗАГВАРЫН
ТОЙМ СУДАЛГАА
2020 оны 9 дүгээр сар


Б.Даваадалай

Эдийн засагч
Дэлхийн Банк

2020 оны 10 дугаар сарын 9

Гол санаа

- **Уул уурхай нь Монголын өнөөдөр, харин ирээдүй нь оюун ухаан - хүмүүн капитал ба институци - байх учиртай**
- **Уул уурхайгаас оюун ухаан уруу чиглэх бүтцийн өөрчлөлтийг дараах 3 зорилтын хүрээнд тодорхойлохоор байна:**




- **Бодлогын үндсэн 4 гол чиглэл:**
 - Макро эдийн засгийн бодлого нь **хэрэглээг тогтворжуулахад** анхаарах;
 - **Хөрөнгө оруулалтын орчинд** дорвитой **шинэчлэж** хувийн хэвшлийн **бүтээмжийг сайжруулах;**
 - Бүтээгдэхүүний төрөлжилтөөс илүүтэй **нөөц, баялгаа төрөлжүүлэхэд** анхаарах;
 - Институцийн ил тод, хараат бус байдал, засаглалыг сайжруулах чиглэлээр **засаглалын суурь шинэчлэлүүдийг хийх.**


Уул уурхай Монголын өнөөдөр бол харин ирээдүй нь оюун ухаан...

- Эдийн засгийн бүтцийн хувьд ижил төстэй улс орнуудтай харьцуулахад Монгол Улс хүмүүн капиталаа дутуу ашиглаж, институцийн чанар сул байна.
- Оюун ухаанд түлхүү суурилсан эдийн засгийн хөгжил илүү тогтвортой, зохистой байхаар байна.

Хүмүүн капитал



Институцийн капитал



Эх сурвалж: Дэлхийн банк (2018с), ДХУ; Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо
Тэмдэглэл: а. Нийт баялагт эзлэх хувиар тооцов

Эх сурвалж: Дэлхийн банк (2018с), ДХУ; Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо
Тэмдэглэл: б. Институцийн чанарыг хууль тогтоомжийн хэрэгжилт болон авлигатай хийх тэмцлийн дундаж оноогоор төлөөлүүлэв

Уул уурхайд түшиглэсэн одоогийн хөгжлийн загвараас доорх 3 үндсэн зорилт/шилжилт үрүү чиглэх

- Уул уурхайгаас оюун ухаан (хүний болон институцийн хөгжил) уруу шилжих үндсэн бүдүүвчийг доор харууллаа.
- Доорх 3 үндсэн зорилт нь ижил цаг хугацаанд хэрэгжих шаардлагатай юм.





- **Тогтвортой байдлыг чухалчлах** (А эсвэл В цэгээс С цэг үрүү шилжих)
- **Бүтээмжийг өсгөх** (С цэгээс D цэг үрүү шилжих)
- **Хүний болон институцийн хөгжилд чиглэх** (D цэгээс E цэг үрүү шилжих)

Зорилт 1: Эдийн засгийн тогтвортой байдлыг чухалчлах (1)...

Макро эдийн засгийн орчин нь хэлбэлзэлтэй өндөртэй байна.

Түүхий эд экспортлогч улс орнууд дунд Монголын макро эдийн засгийн орчин өндөр хэлбэлзэлтэй

Уул уурхайгаас илүү бусад салбаруудын хэлбэлзэл өндөр байгааг анхаарах





Зорилт 1: Эдийн засгийн тогтвортой байдлыг чухалчлах (2)...

- Макро эдийн засаг, түүн дотроо банкны салбар хэлбэлзэл өндөртэй байна

Банкны ашигт ажиллагаа зарим талаар түүхий эдийн үнийн мөчлөгөөс хамаарч байна

Бизнесийн мөчлөгийн өрнөл, уналтын аль алинд нь бодлогын хүчин зүйлс хэлбэлзлийг нэмэгдүүлжээ






Зорилт 1: Эдийн засгийн тогтвортой байдлыг чухалчлах (3)...

- Макро эдийн засгийн хэлбэлзэлийг гол хүчин зүйлсийг ялган харвал,

Гадаад шок болон бодлогын хэрэгжилт эдийн засгийн хэлбэлзлийн дийлэнхийг тайлбарлаж байна

Макро эдийн засгийн бодлогод ерөнхийдөө мөчлөг дагасан шинж ажиглагдаж байна



Эх сурвалж: Монголбанк; Батсуурь нар (2020)

Тэмдэглэл: Тайлбарлагч хувьсагчид нь Хятадын ДНБ-ий өсөлт, зэс, нүүрс, газрын тосны үнэ, бодит ДНБ, хэрэглээний үнийн индекс; ГШХО (ДНБ-ий %), төсвийн зардал (ДНБ-ий %); M2 мөнгө; зээлийн үлдэгдэл; ханш болно

Эх сурвалж: Монголбанк, СЯ; Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо

Тэмдэглэл: Түүхийн эдийн үнийн хөдөлгөөнд суурилан мөчлөгийн уналт, оргилыг тодорхойлов. Оргил жилүүд: 2004–08, 2010–12, 2017–19. Уналтын жилүүд: 2009, 2013–16

Зорилт 1: Тогтвортой байдлыг чухалчлах – Бодлогын тэргүүлэх чиглэлүүд (1)

Хэрэглээг тогтворжуулахад чиглэсэн мөчлөг сөрсөн макро эдийн засгийн бодлого:

- **Төсвийн дүрмийг хялбарчлах** (олон нийтэд ойлгомжтой болгох, дүрмийг түдгэлзүүлэх хугацаа, тохиргоог нарийн тусгах) – Перу улсын жишээ
- **ЗГ-ын өрийг бууруулах**, ил тод байдлыг нэмэгдүүлэх (**ялангуяа төрийн өмчит ААН**), тогтворжуулалтын сангийн үйл ажиллагааг сайжруулах, ирээдүйн өв санд хангалттай хуримтлал үүсгэх
- Нэрлэсэн ханш илүү **уян хатан тогтох** боломжийг бүрдүүлэх, **гадаад валютын интервенцээ хязгаарлах**
- Банкны салбарын хэлбэлзлийг бууруулахад **мөчлөг сөрсөн, зохистой харьцааны хэрэгслүүдийн үр нөлөөг нэмэгдүүлэх** (өөрийн хөрөнгө, өр-орлогын харьцаа)

Төсвийн институцээ сайжруулах:

- **Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (ТТБЗ)-ийн бие даасан байдлыг нэмэгдүүлж**, болзошгүй улс төрийн нөлөөллийг бууруулахад анхаарах
- Төсвийн гол баримт бичгүүдийн талаар ТТБЗ-ийн дүгнэлт, зөвлөмжид **ЗГ-аас албан ёсны хариу өгөх, тодорхой** арга хэмжээ авдаг байх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх

Зорилт 1: Тогтвортой байдлыг чухалчлах – Бодлогын тэргүүлэх чиглэлүүд (2): Төвбанкны бие даасан байдал, засаглал

Банкуудын засаглал болон зарим хяналт, шалгалттай холбоотой хөнгөлөлтөөс голлон шалтгаалж буй санхүүгийн салбарын эмзэг байдлыг бууруулах:

- Дунд хугацааны банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөрийг амжилттай хэрэгжүүлэх (тухайлбал, банкны эзэмшигчдийн төвлөрлийг бууруулах vs Сайн засаглал: “Өмнөх туршлагаа эргэн харах”)

Бие даасан байдлыг бэхжүүлснээр:

- Хяналт, шалгалтын үр дүн нэмэгдэж, хяналт, шалгалттай холбоотой хөнгөлөлтүүд багасна
- Макро эдийн засгийн тогтвортой байдал – Төгрөгийн ханш илүү уян хатан тогтох боломж нэмэгдэх, валютын нөөц өсөх


Төвбанкны бие даасан байдал, засаглалыг сайжруулахад (хяналт, шалгалтын болон санхүүгийн тогтвортой байдлын хүрээнд):

- Төвбанкны үндсэн зорилтыг эргэн харах (Үнийн тогтвортой байдал vs Төгрөгийн ханшийн тогтвортой байдал)
- УИХ-аас жил бүр мөнгөний бодлогын зорилтот инфляцын түвшинг баталдаг нь “Инфляцийг онилох бодлого”-той хэр нийцтэй байгааг эргэн харж, зохих өөрчлөлт оруулах
- Төсвийн шинжтэй үйл ажиллагаанд оролцохоос аль болох татгалзах (Төвбанкны хууль)
- Гадаад секторын тэнцвэртэй нийцтэй байдлаар Төвбанк валютын нөөцөө зохистой удирдах боломжийг нэмэгдүүлэх
- Хяналт, шалгалтын бодлого/хянан шалгагчдын бие даасан байдлын талаарх эрх зүйн орчинг сайжруулах
- Иргэдийн санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэх
- Төсөв, мөнгөний бодлогын уялдаа болон Төвбанкнаас хэрэгжүүлж буй ялгаатай бодлогуудын хоорондын уялдааг хангах

Зорилт 2: Бүтээмжийн өсөлтийг тэтгэх (1)

Монгол Улсад бүтээмжийн өсөлт ихэвчлэн сул байсан бөгөөд энэ нь олон хүчин зүйлсээс хамаарсан байхаар байна. Эдийн засгийн хэлбэлзэл болон валютын ханшийн чангаралт нь уул уурхайн бус салбарын өрсөлдөх чадвар, хөрөнгө оруулалтад бэрхшээл болсоор байна

Бүтээмж дэлхийн жишгээс доогуур байна



Монгол Улс баялгын хараалд өртөхөөс сэргийлэх: Мөчлөгийн өрнөл үед бодит ханш чангарч байв



Эх сурвалж: Дэлхийн банк (2018с); Brandt et al. (2017) аргачлалыг ашиглан тооцов
Тэмдэглэл: ҮХЗБ = үндсэн хүчин зүйлсийн бүтээмж,
PPP= худалдан авах чадварын паритет



Эх сурвалж: Монголбанк; Дэлхийн банкны мэргэжилтнүүдийн тооцоо
Тэмдэглэл: Нэрлэсэн ханш = нэрлэсэн бодит үйлчилж буй ханш

Зорилт 2: Бүтээмжийн өсөлтийг тэтгэх (2)

Өрсөлдөөн сул, санхүүгийн хүртээмжийн асуудал нь бүтээмж сул байх зарим гол хүчин зүйлс байхаар байна.

Өрсөлдөөн сул, гол салбаруудад эзэмшигчдийн төвлөрөл өндөр байна

Компаниуд санхүүгийн эх үүсвэр татаж чадахгүй байна



Эх сурвалж: Банкүүдийн цахим хуудсаас цуглуулав, 2020 оны 5 дугаар сарын байдлаар

Эх сурвалж: Дэлхийн банкны Аж ахуйн нэгжийн судалгаа

Зорилт 2: Бүтээмжийн өсөлтийг тэтгэх – Бодлогын тэргүүлэх чиглэлүүд

Баялгийн хараалд өртөхөөс сэргийлэх макро эдийн засгийн менежмент:

- Эдийн засгийн мөчлөгийн үед Монголбанкны **стерилизацийн бодлогоо** эргэн харж, сайжруулах (Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх)
- **Долларжилт, гадаад валютаарх өр, зээлийг** бууруулах
- Инфляцийн зорилтод тууштай чиглэх, гадаад тэнцвэрийг чухалчлах
- **Өрийн менежментийг** сайжруулах (гадаад валютаарх өрийг бууруулах), **дотоод бондын зах зээлийг** хөгжүүлэх

Бизнесийн орчныг сайжруулах:

- **Өрсөлдөөний** тухай шинэчилсэн үндэсний бодлого батлах
- **Хил орчмын худалдааны зардлыг бууруулж**, хугацааг богиносгох (гааль, хяналт, шалгалттай холбоотой хуулиудыг эргэн харах)
- **Санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх** (зээлийн бүртгэлийн системийг сайжруулах)
- **Төр-Хувийн хэвшлийн уялдааг сайжруулж**, хөрөнгө оруулагчдад ээлтэй орчныг бүрдүүлэх


Чанартай ГШХО-ыг татах:

- Гадаад хөрөнгө оруулагчид болон дотоод компаниудын **хамтын ажиллагааг дэмжих**
- **Хөрөнгө оруулагчийн эрхийг хамгаалах** (хөрөнгө оруулалтыг хамгаалах баталгаа, ү/ц-ны хөрөнгө оруулагчийг хамгаалах)


Зорилт 3. Хөрөнгийн төрөлжилт нь Монгол Улсын бүтээгдэхүүн болон зах зээлийн төрөлжилтөд чухал үүрэгтэй...

Өгөгдсөн хөрөнгө, баялгаа төрөлжүүлж чадаагүйгээс экспорт болон үйлдвэрлэлийн төрөлжилт сул байх шалтгаан болж байна.

Хөрөнгийн төрөлжилт нь бүтээгдэхүүний төрөлжилтийг дагуулна



Монгол Улс хөрөнгө болон бүтээгдэхүүний төрөлжилтөөр бусад улсаас хоцорч байна





Зорилт 3: Хүний болон институцийн хөгжил үрүү чиглэх нь

Хөдөлмөрийн зах зээлийн үр ашиг сул, мөн уул уурхайн орлогын хэт өсөлтийг дагасан засаглалын үзүүлэлтүүд сайнгүй байна

Дээд боловсрол ихээр эзэмшиж байгаа ч залуусын ажилгүйдэл өндөр, боловсролын өгөөж сул байна

Хуулийн хэрэгжилт сул байгаа нь баялгийн өндөр өгөөжтэй холбоотой байхаар байна



Зорилт 3: Хүний болон институцийн хөгжилд чиглэх – Бодлогын тэргүүлэх чиглэлүүд

Хөдөлмөрийн зах зээлийн реформ:

- Хүний нөөцийн бодлоготой нарийн уялдсан **боловсролын чанарын асуудлыг** дахин эргэн харах
- **Чанартай, хүртээмжтэй хүүхэд харах үйлчилгээнд** анхаарах
- Боловсрол, **сургалтын чанарт хяналт тавих** тогтолцоог бүрдүүлэх
- Сургалтын хөтөлбөрийг **зах зээлийн эрэлттэй нягт уялдуулах**, хувийн салбарт эрэлттэй мэргэжлийг түлхүү дэмжих

Ур чадвартай ажиллах хүчинг татах, эх орондоо тогтоон барих:

- Цагаач, гадаадад оршин сууж буй иргэдийн асуудлыг **хариуцсан салбар агентлаг байгуулж**, ажиллуулах. Гадагш гарч буй боловсролтой ажиллах хүчний мэдээллийг нэгтгэх
- Гадаадад буй чадварлаг боловсон хүчинг **улс орныхоо хөгжилд татан оролцуулах** (Малайз улсын туршлага)

Институцийн хөгжил (ил тод байдал, хариуцлага, үр ашигтай улсын хөрөнгө оруулалт)


- Гэрээ хэлцэл, зөвшөөрөл, өмчлөгчийн талаарх **мэдээллийг ил тод болгох** (ялангуяа олборлох салбарын)
- **Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагыг** сайжруулах
- **Төрийн үйлчилгээг цахимжуулах** нэгдсэн, цогц бодлого хэрэгжүүлэх

Харьцангуй давуу талтай салбар болон бүтээгдэхүүнээ дэмжих

- **Боловсруулах салбарыг өргөжүүлэх** хөшүүргийг бий болгох
- Одоогоор хүчинтэй хэрэгжиж буй **худалдааны гэрээ, хамтын ажиллагааг** сайтар ашиглах

Гол санааг эргэн сануулахад...

- **Уул уурхай Монголын өнөөдөр бол харин ирээдүй нь оюун ухаан - хүмүүн капитал ба институци – байх учиртай**
- **Уул уурхайгаас оюун ухаанд чиглэх бүтцийн өөрчлөлтийг дараах 3 шилжилт/зорилтоор тодорхойлж болохоор байна:**



- **Бодлогын 4 гол чиглэл:**
 - **Макро эдийн засгийн бодлого нь хэрэглээг тогтворжуулахад анхаарах;**
 - **Хөрөнгө оруулалтын орчныг дорвитой шинэчилж хувийн хэвшлийн бүтээмжийг дээшлүүлэх;**
 - **Бүтээгдэхүүнийг төрөлжүүлэхээс илүүтэй нөөц, баялгаа төрөлжүүлэхэд анхаарах;**
 - **Институцийн ил тод, хараат бус байдал, засаглалыг сайжруулах чиглэлээр засаглалын суурь шинэчлэлийг хийх.**

**Анхаарал хандуулсан та бүхэнд
баярлалаа**